

УЛС ХООРОНДЫН ШУУДАНГИЙН ИЛГЭЭМЖИЙН ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН ЖУРАМ¹

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Улс хоорондын шуудангийн илгээмжид гаалийн хяналт тавих, гаалийн бүрдүүлэлт хийхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Гаалийн бүрдүүлэлт хийх ажиллагаанд олон улсын жишигт нийцүүлэн хөнгөн шуурхай, чирэгдэлгүй хийгээд эрсдэлгүй явуулах зарчмыг баримтална.

1.3. Улс хоорондын шуудангийн илгээмжид гаалийн бүрдүүлэлт хийхдээ Дэлхийн шуудан холбооны байгууллагын конвенц, Гаалийн тухай хууль, тогтоомж болон энэхүү журмыг мөрдөнө.

1.4. Улс хоорондын шуудангийн илгээмжид Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бичиг, захидал, боодол, илгээлт, шуудангаар илгээж байгаа бусад зүйлс /цаашид илгээмж гэх/ хамаарна.

1.5. Илгээмжид гаалийн хяналт, шалгалт хийхээр задлах, боох, савлах, жигнэх, ажиллагааг тухайн гаалийн байгууллага, хадгалах ажиллагааг шуудангийн байгууллага тус тус хариуцан гүйцэтгэнэ.

1.6. Илгээмжийг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр шуудангийн байгууллага хүлээн авах, задлах, баглаа боодлыг өөрчлөх, хүлээн авагчид олгохыг хориглоно.

1.7. Гаалийн байгууллагагүй аймаг, орон нутагт шуудангийн байгууллагын ажилтныг гаалийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллуулах саналыг тухайн албан тушаалтны анкетын хамт шуудангийн байгууллага гаалийн удирдах төв байгууллагад бүрдүүлж ирүүлнэ.

1.8. Улс хоорондын шуудангийн илгээмжид гаалийн үзлэг, шалгалтыг хил дээрх гаалийн салбар гүйцэтгэх бөгөөд шуудангийн байгууллагад гаалийн ажилтан ажиллана.

Хоёр. Гаалийн бүрдүүлэлт

¹ *ᠨᠠᠶᠢᠨᠣᠨᠨ, ᠶ᠋ᠠᠡᠢ ᠴᠠᠨᠠᠡᠢ ᠨᠠᠡᠳᠤ, ᠠᠶᠢ ᠠᠵᠢᠨᠣᠨᠨ ᠨᠠᠡᠳᠤᠰᠢ 2004 ᠶᠢᠰ 05 ᠠᠢᠠᠳᠠᠳᠤ ᠨᠠᠳᠤᠰᠢ 11-ᠶ᠋ᠡᠡ ᠠᠳᠤᠡᠢ 109/86 ᠠᠢᠠᠳᠠᠳᠤ ᠠᠢᠠᠳᠠᠳᠤ ᠠᠳᠤᠳᠠᠳᠠᠨᠠᠢ.*

2.1. Улсын хилээр олон улсын шуудангийн илгээмжийг нэвтрэх үеэс хил дээрх гаалийн салбар нь хяналтдаа авч гаалийн бүрдүүлэлтийг хийнэ.

2.2. Гаалийн хяналт шалгалт бүрдүүлэлтийг хийсэн тухай тэмдэглэлийг шуудангийн гадуур дагалдах баримт нь дээр хяналтаас хассан болон хяналтад байгаа тухай холбогдох тэмдгийг дарсны дараа өөрийн харьяа гүний гаалийн ажилтанд шилжүүлнэ. Шаардлагатай тохиолдолд хилийн гаалийн байгууллага хяналт шалгалт, бүрдүүлэлт хийх ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

2.3. Гаалийн байгууллага хяналтдаа ирсэн илгээмжийн гадуур, дотуур дагалдах, бусад бичиг баримтыг үндэслэн зохих битүүмжлэлийг шалгаж, илгээмжийн баглаа боодлыг задлаж бүртгэл хөтөлнө. Дахин үзлэг шалгалт хийх шаардлагатай, сэжиг бүхий илгээмж байна гэж үзвэл шалгалт хийнэ.

2.4. Илгээмжийг шалгах үед рентген аппарат, гэрэлтүүлэгч болон шаардлагатай тохиолдолд сургуультай нохой, наркотест ашиглана.

2.5. Илгээмжийн илгээгч, хүлээн авагчийн нэр хаяг нь тодорхой бус хориглосон зүйл агуулсан байж болзошгүй тохиолдолд шуудангийн ажилтан нь илгээмжийг дахин гаалийн хяналт, шалгалт, бүрдүүлэлт хийлгэхээр шилжүүлнэ.

2.6. Илгээмжийг хүлээн авагчид олгох эсвэл хилийн чанадад илгээх хүртлэх хугацаанд тэдгээрийг тээврийн болон шуудангийн төвлөрсөн салбаруудад байгуулсан гаалийн хяналтын талбайд хадгална.

2.7. Илгээмжид дараах бичиг баримтыг үндэслэн гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлт хийнэ. Үүнд:

2.7.1. Улс хоорондын илгээмжийн илгээгч, хүлээн авагч нь хувь хүн бол дагалдах шошго, холбогдох бусад бичиг баримт, хүлээн авагч буюу илгээгчийн мэдүүлэх хуудсаар, бичгээр мэдүүлсэн баримт;

2.7.2. Судалгаа шинжилгээний зориулалттай онцлог бараа, эсхүл хүлээн авагч, илгээгч нь аж ахуйн нэгж, байгууллага бол гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг, холбогдох баримтын хамт.

2.8. Илгээгч, хүлээн авагч нь хилээр нэвтрүүлэх барааны талаар гаалийн байгууллагад үнэн зөв мэдүүлэх бөгөөд улсын хилээр нэвтрүүлэхийг хязгаарласан бараанд зохих зөвшөөрлийг авсан байна.

2.9. Илгээмжийг энэ журмын 2.7-д заасан гаалийн мэдүүлэг, холбогдох бичиг баримттай нь тулган шалгана.

2.10. Гаалийн хяналт, шалгалт хийхэд хүлээн авагч буюу илгээгчийг байлцуулах боломжгүй бол шуудангийн байгууллагын ажилтанг байлцуулах ба энэ тухай хамтран акт үйлдэнэ.

2.11. Илгээмж нь нэр төрөл, тоо хэмжээ, хүндийн жингээрээ дагалдах баримттай тохирохгүй буюу бүрэн бүтэн биш байвал гаалийн болон шуудангийн

байгууллагын ажилтнууд хамтарч акт үйлдэн шуудангийн төв байгууллагад шилжүүлнэ.

2.12. Гаалийн бүрдүүлэлт хийсэн илгээмж бүрийн гадуур болон дотуур дагалдах баримтанд түүнийг хэрхэн шийдвэрлэсэн тухай хяналтын тэмдэг дарж, гарын үсэг зурж, огноог бичин гаалийн улсын байцаагчийн хувийн тэмдгээр баталгаажуулна.

2.13. Монгол улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэх илгээмжийг гаалийн байгууллага хяналтандаа авч, хяналт шалгалт хийж, сэжигтэй илгээмжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

2.14. Улаанбаатар хотоос бусад орон нутагт байгаа гаалийн байгууллага нь өөрийн хариуцах нутаг дэвсгэрт хүлээн авах, илгээх шуудангийн илгээмжид энэ журамд заасны дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

2.15. Гаалийн байгууллагагүй аймаг орон нутгаас хилийн чанадад илгээх илгээмжид тухайн аймаг, орон нутгийн шуудангийн байгууллагын гаалийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гаалийн шалгалт хийж, гаалийн татвар хураамжийг ногдуулна.

2.16. Хилийн чанадаас ирсэн бөгөөд гаалийн байгууллагагүй аймаг, орон нутагт хүлээн авагч нь байгаа илгээмжид гаалийн байцаагч шуудангийн ажилтанг байлцуулан гаалийн хяналт, шалгалт хийж, татвар хураамжийг ногдуулан, нэхэмжлэх бичиж орон нутгийн шуудангийн байгууллагад хүргүүлнэ.

2.17. Тухайн аймаг орон нутгийн шуудангийн байгууллагын гаалийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гаалийн байгууллагын ногдуулсан татвар, хураамжийг илгээмжийг хүлээн авагчид олгох үед төлүүлэн, гаалийн байгууллагын дансанд хийнэ.

2.18. Аймаг, орон нутгийн шуудангийн байгууллага нь тус журмын 3 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу татвар, хураамжийн мэдээгээ гаалийн байгууллагад ирүүлж, тооцоо нийлнэ.

2.19. Монгол Улсын хууль тогтоомжоор улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бараанаас гадна дор дурдсан эд зүйлсийг улс хоорондын шуудан илгээмжээр гаалийн хилээр нэвтрүүлэхийг хориглоно. Үүнд:

- а. Үнэт цаас, Монгол Улсын үндэсний болон гадаад валют;
- б. Иргэний биеийн байцаалттай холбогдох бичиг баримт /эх материал/;
- в. Ариутгал хийгдээгүй хуучин гутал, хувцас, цагаан хэрэглэл;
- г. Аюултай бараа;
- д. Түргэн муудах бараа;
- е. Улс хоорондын шуудангийн илгээмжээр илгээхийг хориглосон бусад

зүйлс.

2.20. Улс хоорондын шуудангийн илгээмжийг дор дурдсан тохиолдолд буцаана. Үүнд:

- а.Гаалийн байгууллага хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрөөгүй;
- б.Илгээгч буюу хүлээн авагч нь гаалийн байгууллагаас ногдуулсан татвар хураамжийг төлөхөөс татгалзсан;
- в.Хүлээн авагч нь тогтоосон хугацаанд ирж аваагүй;
- г.Хүлээн авагчийн хаяг тодорхойгүй.

2.21. Зөрчилд холбогдоогүй бөгөөд гаалийн хяналтын талбайд хадгалах 3 хоногийн хугацаанд гаалийн бүрдүүлэлт хийлгээгүй илгээмжийг гаалийн байгууллага гаалийн түр агуулахад оруулж бүртгэлээр хяналт тавина.

2.22. Хилийн чанадад илгээх 500 ам.доллар, хилийн чанадаас ирүүлж байгаа 1000 ам.доллараас тус тус илүүгүй үнийн дүнтэй, арилжааны шинж чанаргүй илгээмжид хувь хүн, зорчигчийн хуудсаар гаалийн бүрдүүлэлт хийнэ.

2.23. Гаалийн болон бусад албан татвар ноогдохгүй бичиг, захидал, боодол болон 2.22-д заасан үнийн дүнд багтсан илгээлтэд гаалийн бүрдүүлэлт хийсэн хөлс/хураамж/ ногдуулахгүй.

2.24. Шуудангийн буцаах илгээмж,мөн муудсан, чанараа алдсаны улмаас устгагдах,хуулиар зөвшөөрөгдсөн бусад зүйлс агуулсан илгээмжид гаалийн болон бусад албан татварыг ногдуулахгүй.

2.25. Энэ журмын 2.10, 2.11, 2.18, 2.21 дэх зүйлүүдэд хавсралтаар батлагдсан акт, нэхэмжлэх болон татвар хураамжийн мэдээний хүснэгтийг хэрэглэнэ.

Гурав. Улс хоорондын буухиа шуудан

3.1. Буухиа шууданд шалгалт хийж гаалийн бүрдүүлэлт хийхдээ энэ журмын 2.6., 2.10., 2.12 дугаар заалтуудыг дагаж мөрдөнө.

3.2. Улс хоорондын буухиа шуудангаар 2.19-д заасан хоирглосон бараанаас үнэт цаас, валют, гадаад оронд зайлшгүй шаардагдах иргэний бичиг баримтыг илгээж болно.

3.3. Гараас гарт буюу хаягаар хүргэх илгээмжийг шуудангийн байгууллагын ажилтанг байлцуулан гаалийн байцаагч шалгаж, холбогдох татвар хураамж ногдуулан, шуудангийн ажилтанд хүлээлгэж өгнө.

3.4. Гаалийн байгууллага буухиа шууданг тэргүүн ээлжинд, саатал чирэгдэлгүйгээр гаалийн үзлэг шалгалт хийнэ.

----- ○ ○ ○ -----

АКТ №

..... оны ... дүгээр
сарын ... -ний өдөр

.....
ХОТ

----- улсаас ----- дугаарын депешээр -----
----- овогтой ----- -нд -----
дугаартай ----- задлан, гаалийн үзлэг хийхэд дараах зөрүү илрэв.

Үзлэг хийсэн: Гаалийн улсын байцаагч _____ / _____ /
/ гарын үсэг, тэмдэг/

Шуудангийн байгууллагын ажилтан _____
/ _____ /

Хүлээн авагч, илгээгч _____ / _____ /

*Актыг 2 хувь үйлдэж, гаалийн болон шуудангийн байгууллагад хадгална.

Нэхэмжлэх хуудас №

.... оны ... дүгээр
сарын ... -ний өдөр

.....
ХОТ

-----аймаг ----- сум дахь Шуудангийн
байгууллагын дарга ----- -д

Танай ----- -нд

/ Илгээмж хүлээн авагчийн хаяг, нэр/

----- улсаас ирүүлсэн илгээмжид гаалийн улсын
байцаагч ----- гаалийн хяналт шалгалт хийхэд дараах
тооцоо үүссэн тул төлбөрийг барагдуулан ----- банкны ----- салбар
дахь УБГГ-ын ----- тоот дансанд төвлөрүүлж, төлбөрийн даалгаврыг
----- -д ирүүлэхийг мэдэгдье.

Үүнд: а. Гаалийн татвар ----- ₮

б. НӨТ ----- ₮

Бүгд татварт ----- ₮

в. Гаалийн бүрдүүлэлтийн хураамж ----- ₮

Бүгд ----- ₮ болно.

Гаалийн улсын байцаагч -----

Гаалийн татвар, хураамжийн мэдээ

№	Нэхэмж-лэлийн		Татвар	Хураамж	Дагаврын №	Барааг эзэнд олгосон өдөр	Гаальд мөнгө шилжүүлсэн өдөр	Мөнгө шилжүүлсэн албан тушаалтан
	огноо	№						
ДҮН								

Мэдээ гаргасан:

_____ аймгийн ШБ-ын гаалийн

итгэмжлэгдсэн төлөөлөгч _____ /

/

Гаалийн бүрдүүлэлт хийсэн мэдээ

№	Дагалдах		Татвар ногдуулсан хувь хэмжээ	Татвар барагдуул- сан хувь хэмжээ	Илэрсэн зөрчил	Шийдвэр- лэсэн байдал	Илгээм- жийн нэр төрөл	Илгээм- жийн тоо, жин
	Гадуур	Дотуур						
ДҮН								

Илгээмжийн нэр:

----- /-----/